

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/60/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273465 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.20 № 01/143
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь "Бүтээлчээр сэтгэж", Төрийн албан хаагчид нь "Нийтийн төлөө үйлчилдэг- хариуцлагатай албан хаагч" уриатайгаар 2022 оны бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажлыг бодитой, хэмжиж болохуйц төлөвлөн, иргэдэд ээлтэй, үр нөлөөтэй ажлуудыг хэрэгжүүлэн, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийг сайжруулж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,057,308.12	32,354,258.12
35	БАРАА МАТЕРИАЛ	25,232,308.12	31,529,258.12
35100	Түүхий эд материал	5,443,118.12	4,769,868.12
35110	Тусгай зориулалттай материал	5,443,118.12	4,769,868.12
35400	Хангамжийн материал	19,789,190.00	21,759,390.00
35410	Бичиг хэргийн материал	825,600.00	697,400.00
35420	Аж ахуйн материал	10,313,590.00	10,671,990.00
35430	Сэлбэг хэрэгсэл	120,000.00	120,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,530,000.00	10,270,000.00
35600	Мал амьтад	0	5,000,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	825,000.00	825,000.00
36600	Бусад нөөц	825,000.00	825,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,347,801,031.29	1,644,202,577.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,347,801,031.29	1,644,202,577.58
39200	Биет хөрөнгө	1,306,446,821.29	1,602,890,397.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,245,685,356.82	1,336,541,879.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	-236,409,766.21	-299,925,666.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	117,250,000.00	216,959,090.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-91,084,000.02	-38,801,000.02
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	101,546,433.00	234,348,659.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,031,838.60	-65,412,369.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,754,140.77	143,896,610.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,115,885.23	-39,229,990.97
39209	Зам, гүүрийн байгууламж	145,535,664.00	145,535,664.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-25,356,783.24	-31,695,979.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,400,000.00	31,400,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-31,400,000.00	-31,400,000.00
39217	Ном	673,500.00	673,500.00
39300	Биет бус хөрөнгө	41,354,210.00	41,312,180.00
39301	Програм хангамж	420,300.00	420,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-126,090.00	-168,120.00
39303	Бусад биет бус хөрөнгө	41,060,000.00	41,060,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,373,858,339.41	1,676,556,835.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,373,858,339.41	1,676,556,835.70
51	Засгийн газрын хувь оролцоо	1,373,858,339.41	1,676,556,835.70
51100	Засгийн газрын оруулсан капитал	578,921,887.36	578,921,887.36
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	578,921,887.36	578,921,887.36
51200	Хуримтлагдсан үр дүн	475,359,435.99	778,057,932.28
51210	Өмнөх үеийн үр дүн	380,872,649.81	475,359,435.99
51220	Тайлант үеийн үр дүн	94,486,786.18	302,698,496.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	319,577,016.06	319,577,016.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,373,858,339.41	1,676,556,835.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	680,827,290.00	836,561,649.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	181,617,124.00	725,546,439.00
120	Нийтлэг татварын бус орлого	181,617,124.00	317,992,139.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	175,978,484.00	317,992,139.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,638,640.00	0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	407,554,300.00
123004	Улсын төсөвт орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	0	407,554,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	499,210,166.00	111,015,210.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,005,466.00	111,015,210.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,226,140.00	500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	60,874,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	73,331,831.00	7,474,305.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,447,495.00	42,166,105.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	402,204,700.00	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	402,204,700.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	583,352,731.44	533,863,153.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	583,352,731.44	517,759,203.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539,175,995.87	450,483,115.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,959,442.71	203,689,995.20
210101	Үндсэн цалин	154,327,284.55	158,481,175.08
210102	Нэмэгдэл	37,143,392.80	33,883,751.37
210105	Гэрээт ажлын хөлс	29,488,765.36	11,325,068.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,305,359.89	25,348,270.76
210201	Тэтгэврийн даатгал	20,493,177.04	17,364,686.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,225,052.59	2,111,616.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,779,982.66	1,629,520.02
210204	Ажилгүйдлийн даатгал	436,658.56	380,571.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,370,489.04	3,861,875.86

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,731,208.00	54,934,195.00
210301	Гэрэл, цахилгаан	7,077,234.00	5,917,321.00
210302	Түлш, халаалт	66,515,974.00	49,016,874.00
210303	Цэвэр, бохир ус	138,000.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	18,896,692.00	27,848,956.00
210401	Бичиг хэрэг	1,837,100.00	3,475,200.00
210402	Тээвэр, шатахуун	12,148,730.00	22,844,686.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,479,712.00	1,529,070.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	863,600.00	0
210408	Бараа материал акталсны зардал	2,567,550.00	0
2105	Нормативт зардал	270,700.00	1,218,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	270,700.00	1,218,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,414,500.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	6,414,500.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,729,500.00	4,090,000.00
210702	Дотоод албан томилолт	1,729,500.00	4,090,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,591,844.20	794,490.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,541,275.00	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,579.20	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,990.00	287,990.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	74,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,276,749.07	131,058,608.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,939,692.77	12,349,846.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	93,297,056.30	118,708,762.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,176,735.57	67,276,087.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	15,963,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	14,963,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	43,676,735.57	51,312,687.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,676,735.57	51,312,687.54
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	16,103,950.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	16,103,950.00
223001	Хаагдсан данс	0	16,103,950.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	97,474,558.56	302,698,496.29
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,987,772.38	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	187,132.38	0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,800,640.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	94,486,786.18	302,698,496.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	499,210,166.00	518,569,510.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	499,210,166.00	518,569,510.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	407,554,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	407,554,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,005,466.00	111,015,210.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,226,140.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	73,331,831.00	111,015,210.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,447,495.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	402,204,700.00	0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	402,204,700.00	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,450,056.37	397,360,690.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,450,056.37	397,360,690.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,273,320.80	330,084,602.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,959,442.71	203,689,995.20
210101	Үндсэн цалин	154,327,284.55	158,481,175.08
210102	Нэмэгдэл	37,143,392.80	33,883,751.37
210104	Урамшуулал	0	11,325,068.75
210105	Гэрээт ажлын хөлс	29,488,765.36	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,305,359.89	25,348,270.76
210201	Тэтгэврийн даатгал	20,493,177.03	17,456,716.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,225,052.59	2,036,899.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,779,982.67	1,629,520.02
210204	Ажилгүйдлийн даатгал	436,658.56	379,274.34
210205	Эрүүл мэндийн даатгал	4,370,489.04	3,845,859.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,731,208.00	55,285,245.00
210301	Гэрэл, цахилгаан	7,077,234.00	5,884,321.00
210302	Түлш, халаалт	66,515,974.00	49,116,924.00
210303	Цэвэр, бохир ус	138,000.00	284,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	16,507,042.00	16,374,835.00
210401	Бичиг хэрэг	2,015,000.00	2,471,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,148,730.00	10,981,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,479,712.00	1,529,070.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	863,600.00	1,393,225.00
2105	Нормативт зардал	600,000.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,729,500.00	4,090,000.00
210702	Дотоод албан томилолт	1,729,500.00	4,090,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,591,844.20	794,490.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,541,275.00	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,579.20	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,990.00	287,990.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	74,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,348,924.00	23,001,767.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,244,924.00	23,001,767.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,176,735.57	67,276,087.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	15,963,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	14,963,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	43,676,735.57	51,312,687.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,676,735.57	51,312,687.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	30,760,109.63	121,208,820.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	30,760,109.63	121,208,820.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,760,109.63	121,208,820.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,760,109.63	121,208,820.00
223001	Бусад хөрөнгө	19,934,809.63	19,090,650.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,825,300.00	102,118,170.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-30,760,109.63	-121,208,820.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	578,921,887.36	320,704,650.61	379,745,015.26	1,279,371,553.23
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,127,634.55	1,127,634.55
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	578,921,887.36	320,704,650.61	380,872,649.81	1,280,499,187.78
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-1,127,634.55	0	-1,127,634.55
9	Тайлант үеийн үр дүн	0	0	94,486,786.18	94,486,786.18
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	578,921,887.36	319,577,016.06	475,359,435.99	1,373,858,339.41
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	578,921,887.36	319,577,016.06	475,359,435.99	1,373,858,339.41
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	578,921,887.36	319,577,016.06	475,359,435.99	1,373,858,339.41
19	Тайлант үеийн үр дүн	0	0	302,698,496.29	302,698,496.29
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	578,921,887.36	319,577,016.06	778,057,932.28	1,676,556,835.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	428,176,800.00	371,032,301.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	385,271,400.00	333,362,981.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,308,000.00	317,399,581.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,389,300.00	203,689,995.20
210101	Үндсэн цалин	172,864,400.00	158,481,175.08
210102	Нэмэгдэл	42,524,900.00	33,883,751.37
210104	Урамшуулал	0	11,325,068.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,383,200.00	25,348,270.76
210201	Тэтгэврийн даатгал	18,767,600.00	17,456,716.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,153,900.00	2,036,899.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,723,100.00	1,629,520.02
210204	Ажилгүйдлийн даатгал	430,800.00	379,274.34
210205	Эрүүл мэндийн даатгал	4,307,800.00	3,845,859.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,027,700.00	54,549,195.00
210301	Гэрэл, цахилгаан	5,230,500.00	5,884,321.00
210302	Түлш, халаалт	57,297,200.00	48,380,874.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	284,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,938,800.00	15,006,545.00
210401	Бичиг хэрэг	2,337,400.00	2,337,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,595,400.00	9,747,250.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,506,000.00	1,529,070.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	1,393,225.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,489,200.00	4,090,000.00
210702	Дотоод албан томилолт	4,489,200.00	4,090,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,281,300.00	794,490.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,954,300.00	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	230,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	565,000.00	287,990.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	74,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,298,500.00	12,421,086.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,298,500.00	12,421,086.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,963,400.00	15,963,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,963,400.00	15,963,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,963,400.00	14,963,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,905,400.00	37,669,320.00
223001	Бусад хөрөнгө	42,905,400.00	37,669,320.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	428,176,800.00	407,554,300.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	407,554,300.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	407,554,300.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	385,271,400.00	0
320001	Орон нутгийн төсвөөс	385,271,400.00	0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	42,905,400.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	42,905,400.00	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		36,224,521.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		36,224,521.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		36,224,521.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		736,050.00
210302	Түлш, халаалт		736,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,368,290.00
210401	Бичиг хэрэг		134,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,234,290.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	34,120,181.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		34,120,181.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		60,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		60,000,000.00
222001	Тоног төхөөрөмж		60,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	96,224,521.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		96,224,521.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		499,047.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		60,874,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		(7,315,431.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		42,166,105.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь “Бүтээлчээр сэтгэж”, Төрийн албан хаагчид нь “Нийтийн төлөө үйлчилдэг- хариуцлагатай албан хаагч” уриатайгаар 2022 оны бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажлыг бодитой, хэмжиж болохуйц төлөвлөн, иргэдэд ээлтэй, үр нөлөөтэй ажлуудыг хэрэгжүүлэн, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийг сайжруулж ажиллах чиг үүрэг бүхий Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 15 зорилтын хүрээнд 66 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 97,9%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Засаг даргын Тамгын газрын дарга 1, удирдах 2, гүйцэтгэх 4, үйлчилгээний ажилтан 10 бүгд 17 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн "Дотоод хяналтын баг байгуулах тухай" А/12 тушаал, 5 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг мөрдөж ажилласан байна.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналт шалгалтын баг нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 11 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн 72,7 хувьтай хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын баг нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай

бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилладаг. Энэ онд шилэн дансанд хяналт шалгалт хийсэн байна.

Тус байгууллагад тайлант онд Төв аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2022 оны 5 дүгээр сард 2020 болон 2021 оны санхүүгийн тайлангийн баримтад хяналт шалгалт хийсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь 28 дэд бүлэгт бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна. НББ-ийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 302,698.5 мянган төгрөгөөр буюу 22,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	25,232.3	31,529.3	6,297.0
Үндсэн хөрөнгө	1,347,801.0	1,644,202.6	296,401.6
Нийт хөрөнгө	1,373,858.3	1,676,556.8	302,698.5
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,373,858.3	1,676,556.8	302,698.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,373,858.3	1,676,556.8	302,698.5

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн дансанд орлого зарлагын хөдөлгөөн хийгдсэн болон хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалан өмнөх оны үзүүлэлтээс 296,401.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Засгийн Газрын

оролцоо дансны үлдэгдэл 1,676,556.8 мянган төгрөг болж 302,698.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 465,437.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 80,166.2 мянган төгрөгөөр бууруулж Төв аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 5 дугаар албан бичгийн хавсралтаар 2022 оны урсгал зардлын төсвийг 385,271.4 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Тайлант хугацаанд төсөвт 1 удаагийн тодотгол хийгдэж 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоолоор урсгал зардлын төсвийг хэвээр нь үлдээж 385,271.4 мянган төгрөгөөр ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 / орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага/ хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 385,271.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 36,522.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 348,749.4 мянган төгрөг буюу 90,5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 36,522.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80101 үндсэн үйл ажиллагааны зардал	271,526.6	271,526.6	0	100,0
2	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80103 гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	40,625.2	13,529.1	27,096.1	33,3
3	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80106 баг хорооны үйл ажиллагааны зардал	38,357.7	38,002.5	355.2	99,1
4	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	15,963.4	15,963.4	0	100,0
5	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	42,905.4	37,669.3	5,236.1	87,8

	80918 бусад				
6	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81102 орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0	100,0
7	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 82801 улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100,0
8	71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 81701 байгаль орчныг хамгаалах	6,298.5	3,362.0	2,936.5	53.4
9	71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 82212 хог хаягдал орчны бохирдол	2,500.0	1,601.9	898.1	64.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 7,474.3 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаас 500.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 60,874.8 мянган төгрөг, үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 42,166.1 мянган төгрөг, нийт 111,015.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гэрэл цахилгаан, түлш, халаалтад 2,029.1 мянган төгрөг, бичиг хэрэг, тээвэр шатахуунд 1,942.5 мянган төгрөг, тоног төхөөрөмж 60,000.0 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээний зардалд 47,420.0 мянган төгрөг нийт 111,015.2 мянган төгрөг зарцуулж, 14,790.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хөтөлбөр 87,2%	376,472.9	328,399.0

2	71411	2022.01.01- 2022.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	Хөтөлбөр 56,4%	8,798.5	4,964.0
---	-------	---------------------------	---	-------------------	---------	---------

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 51,312.7 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянцогт сумын ИТХ-ын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан 2022 оны нийт зарлага 385,271.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 5,779.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,334.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13

орлогын, 45 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 2 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	96,868.2	2	96,868.2	100
Зөвлөмж					
Нийт дүн	2	96,868.2	2	96,868.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 407,554.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 407,554.3 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1. Тус байгууллага тайлант онд орон нутгийн төсвөөс санхүүжих орлогын 407,554.3 мянган төгрөгийг улсын төсвөөс төвлөрүүлэн шилжүүлэг дансанд тусгаж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 26,378.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 23,358.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,020.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

1. Тус байгууллага тайлант онд сандал, ширээ, сейф, компьютер нийт 23,358.2 мянган төгрөгөөр тушаалгүй болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланд тусгаагүй тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жижиг мөнгөн сангийн журмаар бараа ажил үйлчилгээнд 300.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд 500.0 мянган төгрөг авах эрхтэйгээс тус байгууллага баяр наадмын зардалд 1,869.1 мянган төгрөгийн бэлэн мөнгө авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид бэлэн мөнгөний хэмжээг хэтрүүлэхгүй байх.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шатахууны 1,151.1 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудас дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаж байх.

3. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 2022 онд байршуулах мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 11 мэдээлэл, огт мэдээлээгүй 11 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, тухай бүр мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага нь орон нутгийн төсвөөс санхүүжих орлогын 407,554.3 мянган төгрөгийг улсын төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг дансанд тусгаж тайлагнасан байна.	1	407,554.3			1	407,554.3	1	407,554.3				
Дүн	1	407,554.3			1	407,554.3	1	407,554.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Тус байгууллага нь сандал, ширээ, сейф, компьютер нийт 23,358.2 мянган төгрөгөөр тушаалгүй болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланд тусгаагүй тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авсан байна.	1	23,358.2			1	23,358.2						
Тус байгууллага баяр наадмын зардалд 1,869.1 мянган төгрөгийн бэлэн мөнгө авсан байна.	1	1,869.1					1	1,869.1				
Шатахууны 1,151.1 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудас дутуу байна.	1	1,151.1					1	1,151.1				
Дүн	3	26,378.4			1	23,358.2	2	3,020.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 2022 онд байршуулах мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 11 мэдээлэл, огт мэдээлээгүй 11 мэдээлэл байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								